

ИХ СУРГУУЛИУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА

Монгол Улсын Боловсролын хууль, шинжлэх ухаан, технологийн хуульд туссан үзэл баримтлал, үүрэг зорилтуудыг хэрэгжүүлж, хүмүүнлэгийн чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээний ажлын уялдааг хангах, хүчин чармайлтаа нэгтгэх зорилгоор ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Монгол Улсын Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн хооронд хамтран ажиллах гэрээ байгууллаа. Гэрээний үндсэн чиглэл нь Монгол Улс дахь хүмүүнлэгийн болон гадаад орон судлалын салбарт явуулж буй сургалт, эрдэм шинжилгээний ажлын уялдааг хангаж, харилцан үр ашигтай хамтран ажиллахад үйл ажиллагаагаа чиглүүлэх юм.

Гэрээ байгуулах ёслолын үйл ажиллагаа 2012 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр ХУИС-ийн хурлын танхимд болж ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор(Sc.D), профессор Л.Хайсандай, Монгол Улсын Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн захирал, академич Б.Чулуундорж нар гэрээнд гарын үсэг зурлаа. Ёслолын үйл ажиллагаанд манай хүрээлэнгээс Европ судлалын секторын эрхлэгч доктор(Ph.D) Д.Золбоо, доктор(Ph.D) Б.Нарантунгалаг, докторант М.Болормаа, Ж.Орхон, ХУИС-ийн талаас Хэл, соёлын сургуулийн захирал доктор, профессор Т.Төрбат, доктор (Sc. D), профессор Ч.Зэгиймаа, Олон улсын харилцааны тэнхимийн эрхлэгч П.Мягмардорж нар байлцаж, санал бодлоо солилцлоо.

Гэрээний дагуу хоёр тал олон улсын харилцаа, гадаад орон судлалын чиглэлээр хоёр талаас хамтран тодорхой сэдэв, чиглэлээр ажиллах боломжийг эрж хайх, хамтарсан судалгааны ажил санаачлах, багш, оюутан, магистрант, докторантын эрдэм шинжилгээний ажлыг хүрээлэнгийн судалгааны ажилд ойртуулах, оюутан, магистрын оролцоотойгоор хамтын судалгаа хэрэгжүүлж үр дүнг хэвлэн нийтлүүлэх, зохих нөхцөл хангах зэрэг хамтран ажиллах олон чиглэл тусгагдсан байна.

2012 оны 12 дугаар сарын 21-ний өдөр тус хүрээлэн МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуультай хамтран ажиллах гэрээг байгуулав. Хамтын ажиллагааны гол чиглэл, зорилго бол эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагуудын хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх, бэлтгэн гаргаж буй мэргэжилтний мэдлэг чадварыг сайжруулах, ажлын арга барил, дадал эзэмшүүлэх, эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудыг сургалтын ажилд өргөнөөр оролцуулах, хамтарсан судалгааны ажил, төсөл гүйцэтгэх, шинжлэх ухаан технологийн ололт амжилтыг практикт нэвтрүүлэх, ажлын арга, туршлагаас харилцан суралцах, ном сэтгүүл, бүтээлээ харилцан солилцох явдал гэдгийг хоёр талын удирдлагууд онцлон тэмдэглэж байв. Мөн ОУСХ, Гадаад, хэл соёлын сургуулийн хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд нэлээд идэвхижиж байгаа тул хоёр талын хамтын ажиллагааг албан ёсны хэлбэрт оруулах, эрх зүйн үндэслэлийг бий болгох зайлшгүй шаардлага байсныг онцлон дурдаж байв.

Гэрээний дагуу хүрээлэнгийн зүгээс хамтарсан төсөл боловсруулж,

судалгааны ажил гүйцэтгэхэд эрдэм шинжилгээний ажилтнуудаа оролцуулах, ажиллах боломжоор хангах, өөрсдийн судалгааны чиглэлийн дагуу оюутнуудад лекц, семинар, сонгон судлах хичээл заах, оюутны дадлагын ажил удирдах багш нарыг томилж ажиллуулах, Бүс нутаг судлал, Орос, Хятад, Япон, АНУ, Солонгос ба Зүүн өмнөд Ази судлал болон Монголын гадаад харилцааны түүхийн чиглэлээр оюутны дадлага, бакалавр, магистрын дипломын ажил, судлагааны төслийг хүрээлэн дээрээ хийлгэх, удирдах, хүрээлэнгийн эрдэмтдийг магистрант, докторантуудад хичээл заалгах, эрдэм шинжилгээний ажлыг нь хамтран удирдахад татан оролцуулах зэрэг ажлыг хариуцан гүйцэтгэхээр болов.

Сургуулийн зүгээс хүрээлэнгийн эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудаар хичээл заалгах, оюутны дадлага, дипломын ажил, төсөл удирдуулах, хүрээлэнд уригдан ирсэн зочин профессорыг МУИС-ийн гадаад оюутны байранд хөнгөлөлттэй байрлуулах, Гадаад хэл, соёлын сургуульд суралцаж буй Олон улс судлалын хүрээлэнгийн магистрант, докторантад сургалтын төлбөрийн зохих хөнгөлөлт үзүүлэх зэрэг олон ажил багтсан байна.

ШУА-ийн хүрээлэнгүүдийн II нэгдсэн байранд гэрээнд гарын үсэг зурах ёслолын ажиллагаанд хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D) Л.Хайсандай, МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуулийн захирал, профессор Д.Бадмаанямбуу болон хоёр талын эрдэмтэн судлаач, багш нар оролцов. Хамтын ажиллагааны гэрээнд хүрээлэнг төлөөлж Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D) Д.Шүрхүү, МУИС-ийн Гадаад хэл, соёлын сургуулийг төлөөлж доктор (Ph.D) Д.Сайнбилэгт нар гарын үсэг зурсан байна.

Мэдээ бэлтгэсэн С.Азжаргал